МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны .... дугаар сарын .... -ний өдөр | Дугаар ..... | Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн “Хөвсгөл дулааны станц” ТӨХК-иас ирүүлсэн хүсэлтийг хэлэлцээд Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Хөвсгөл дулааны станц” ТӨХК (Д.Цанлигрэнчин)-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 463 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Б.Болор-Эрдэнэ)-нд даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2022 оны .... дугаар сарын ... -ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ

1. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт		Төг/м^3	1,996.8
	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/ГЖ	17,758.5
		тогтмол	Төг/м^3	1,057.2
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт		Төг/м^3	1,200.0
	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/ГЖ	13,660.4
		тогтмол	Төг/м^3	813.3
3	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, “0”-ын өрөөний халаалт хамаарна)		Төг/м^2	600.0
4	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан		Төг/хүн	6,000.0
			Төг/м^3	3,000.0
5	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	41 м^2 хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	3,000.0
		41-81м^2 талбайтай айл өрх	Төг/сар	5,000.0
		81 м^2-с дээш талбайтай айл өрх	Төг/сар	10,000.0